САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2016 оны 07 сарын 27 өдөр Дугаар 242 Улаанбаатар хот

"Дархан брокер ҮЦК" ХХК-ийн
тусгай зөвшөөрлийг сэргээх тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.3, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.3, 63 дугаар зүйлийн 63.1.5, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.4, Хорооны 2015 оны 406 дугаар тогтоолоор батлагдсан "Үнэт цаасны зах зээлийн зохицуулалттай зарим үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл олгох, бүртгэх журам"-ын 8.2 дахь заалтуудыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. "Дархан брокер ҮЦК" ХХК-ийн үнэт цаасны зах зээлд брокер, дилерийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлсэн зөрчлийг арилгасан тул тусгай зөвшөөрлийг сэргээсүгэй.

2. Хөрөнгө оруулагч, үйлчлүүлэгчдийн хууль ёсны эрх ашгийг дээдлэн, хууль тогтоомжоор хүлээсэн үүргийг чанд биелүүлж ажиллахыг үүрэг болгож, дахин зөрчил гаргасан тохиолдолд хууль тогтоомжид заасан хариуцлага хүлээлгэхийг "Дархан брокер ҮЦК" ХХК /Ж.Очирсүх/-д анхааруулсугай.

3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Ц.Нацагдорж/-нд даалгасугай.

ДАРГЫН ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ,
ДЭД ДАРГА Э.БАТБОЛД